



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/242

Чингис хот

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах
өдрийг нийтээр тэмдэглэн өнгөрүүлэхийг
хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Улсын онцгой комиссоос ирүүлсэн чиглэлийн дагуу "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг нийтээр тэмдэглэхийг хязгаарлаж, гэр бүлийн хүрээнд тэмдэглэхийг уриалсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц ИДЭРБАТ

231011536